

Сургуулиас түр чөлөөлөх тухай мэдэгдэл

Утсан орчуулгын үйлчилгээг ашиглан сургуультай холбогдох нь

Сурагчийн нэр
Name of student

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа

Хавсаргасан захидалд NSW мужийн Боловсролын Яамны Сурагчийн Зан Авирын Тухай Бодлого, мөн Сургуулиас Түр Чөлөөлөх болон Хөөх Журмын дагуу таны хүүхдэд өгсөн сургуулиас түр чөлөөлөх тухай мэдэгдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан болно.

Уг захидалд сургуулиас түр чөлөөлөх тухай болон таны хүүхдийг сургуульдаа буцаж сурахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө зэргийг хэлэлцэх шийдвэрлэх хуралд таныг оролцохыг урьж байна. Сургууль тантай холбогдоход уулзалтын үеэр танд орчуулагч хэрэгтэй эсэхийг бидэнд мэдэгдэнэ үү. Бид үүнийг зохицуулах болно. Хэрэв танд хавсаргасан захидлыг ойлгоход хүндрэлтэй байвал сургуультай холбоо барина уу. Бид танд тайлбарлаж өгөх болно.

Таны хүүхэд сургуулиас түр чөлөөлөгдсөн тохиолдолд мэдэж байх шаардлагатай мэдээллийг мөн хавсаргав.

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.

Захирлын нэр
Name of Principal

Захирлын утасны дугаар
Principal's phone number